

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭНХ ТАЙВАН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БҮСИЙН
БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧДОД**

Бага хурлын хүндэт төлөөлөгчид, зочид оо!

Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хуралд оролцогч Та бүхэнд монголын ард түмэн, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн газрын өмнөөс болон хувиасаа халуун мэндчилгээ дэвшүүлье.

Прага хотноо чуулах «Энх тайван, аж амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» дэлхий дахины Ассамблейг угтсан Танай бага хурал олон улсын байдал улам ярвигтай хурцадсан үед болж байна.

Даян дэлхийд жанжлах зорилго өвөрлөсөн империализмын хэт түрэмгий бүлгийнхэн зэвсэглэлийн хойноос, ялангуяа цөмийн зэвсгээр улангасан хөөцөлдөж, эрх чөлөө, нийгмийн дэвшлийн замаар замнах гэсэн улс түмний хүсэл зоригийг газар сайгүй мохоон дарах, социалист орнуудын эсрэг «загалмайтны аян дайн» зохион байгуулахыг эрмэлзэж байна. Үүний уршгаар хүн төрөлхтөнийг нөмөрсөн халуун цөмийн хөнөөлт сүйрлийн гамшигт аюул занал хэмжээлшгүй нэмэгдэж байна.

Империализмын дэлхийг хамарсан стратегийн бодлогод манай гаригийн хүн амын тэн хагасаас илүү нь оршин суудаг томоохон тив-Ази тив онцгой байр суурь эзэлж байна. Сүүлийн үед энэ тивийн бүрэн эрхт орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, тэдгээр орныг империализмын түрэмгий бодлогын эргүүлэгт татаж оруулах гэсэн харгис хүчний оролдлого илт хүчтэй болов,

Ази тивийн өргөн уудам зарим нутаг харийнхны «амин чухал эрх ашгийн» бүс болон зарлагдаж, тэнд гадаадын цэргийн бааз, түшиц газрын олноор нь яаравчлан байгуулж байна. Ази, Дорнод Африкийн бүрэн эрхт олон улс гүрний нутаг дэвсгэрийг хамруулан хариуцсан цөмрөн довтлох цэргийн хүч, түүний нэгдсэн командпалыг байгуулж байна.

Азийн улс гүрэн, ард түмний хооронд харилцан үл итгэх, хардаж сэрдэх байдлыг хөндлөнгөөс хорон зорилго өвөрлөн хүчээр бий болгож; тэднийг юугаар ч зөвтгөшгүй асар их хөрөнгө бүрэлгэн, зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэж байна. Ойрхи, Дундод Дорнод, Персийн булан, Энэтхэгийн далай, Зүүн өмнөд Ази, Алс Дорнодын алинд нь ч хурцадмал байдлын хуучин голомтуудыг ужигруулж, зөрчилдөөний шинэ үүр уурхайг үүсгэн дэвэргэж байна.

Ази, Номхон далайн сав газарт үйл явдлын өрнөлт ийм байгаа нь энэ нутгийн улс түмний төдийгүй даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт үндсээрээ харшилж байна. Энэ байдал нь тэрхүү аюулт хандлагыг сөрөн давж, буцааж ухраахын тулд ямагт сонор сэрэмжтэй байж, хүч чармайлтаа идэвхжүүлэхийг энхийг эрхэмлэгч бүх хүчнээс шургуу шаардаж байна. Эх дэлхийнхээ энх амгаланг эрхэмлэгч бүхний эрс шийдэмгий үйл ажиллагаа, эв нэгдэл хэрэгтэй байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тухайд гэвэл, манай улс Ази тивийн улс гүрэн, ард түмнүүдийн хооронд найрсаг хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх үндсэн дээр энэ тивд бат бэх энх тайвныг ханга

хын төлөө гуйвалтгүй зогсож байна. Маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд түрэмгийлэл үйлдэх, хүч хэрэглэх явдлыг Ази, Номхон далайн бүсийн улс хоорондын харилцаанаас таягдан хаяхын төлөө Бүгд Найрамдах Монгол Ард Улс тууштай тэмцэж байна. Азид болон даян дэлхийд улс төрийн уур амьсгалыг үндсээр нь эрүүлжүүлэхэд чиглэсэн ах дүү социалист орнуудын оновчтой тодорхой саналуудыг бид бүрэн дүүрэн дэмжиж байна.

Энх тайван, бүх нийтийн аюулгүй байдлыг бэхжүүлэх ариун үйлсэд Танай бага хурал нэр төртэй хувь нэмэр оруулна гэдэгт бат итгэж байгаагаа илэрхийлье.

Хурлынхаа үйл ажиллагаанд болон улс түмэн бүрийн хийгээд хүн бүхний эн тэргүүний эрх энх амгалан аж төрөх эрхийг хангахын төлөө тэмцэлд энхийг эрхэмлэгч бүх хүчийг нягтруулах үйлсдээ их амжилт олохыг бага хуралд оролцогчдод чин сэтгэлээсээ ерөөе.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Арды Их Хурлын Тэргүүлэгчдийн
дарга Ю. ЦЭДЭНБАЛ

Улаанбаатар хот, 1983 оны дөрөвдүгээр
сарын 26.